



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.СУГАР ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn


20210615 № 0576462
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Баянтээг багийн Хүн эмнэлгийн эрхлэгч, их эмчээр томилогдохоор нэр дэвшсэн Ганбаатарын Билгүүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журмын 7 дугаар зүйлийн 7.2-т "Төрийн албаны зөвлөл, харьяа салбар зөвлөл нь сонгон шалгаруулалтын тайланг хянаж, шалгалтаар хамгийн өндөр оноо авсан оролцогчийг албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлнэ" гэсэн эрх зүйн зохицуулалттай байх тул нэр дэвшигчийг түр болон жинхлэн томилох эсэхийг Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэхээр байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА, ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

0711838



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.СУГАР ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2021.11.08 № 05/11916
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Шарга багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Оюун-Эрдэнийн Цэрэннадмид, Баянтээг багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Баттулгын Базарсад, Өндөрмөөг багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Ойдоврэнчингийн Мягмар, Цагаан-Овоо багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Цэрэнбатын Мөнх-Эрдэнэ нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан бусад хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

142103020122



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.11.22 № 05/15718
танай _____ -ны № _____ -т


ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН БАЯНТЭЭГ
БАГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ЦЭРЭНДОЛГОР ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Баянтээг багийн Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Цэрэннадмидын Цэвэлмаагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР



ЭНХБОЛД

1422003020661